



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/017/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040	Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум	Ахлах аудитор: Утас: 7036-3036	Ц.Отгонбаяр Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayarts@audit.gov.mn">Otgonbayarts@audit.gov.mn</a>
2026 он	Аудитор: Утас: 7036-3047	Б.Наранцэцэг Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.mn">Narantsetsegba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-26
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11-12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-21
4. Аудитын тайлан	21-24
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. Аудитын илрүүлэлт	24-32
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	33-34

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОБГ	Онцгой байдлын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Э.ОДГАРАВ ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № ЦА-2026/017/НАСТАТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус суманд ой хээрийн түймэр гарсантай холбоотойгоор Засаг даргын нөөц хөрөнгөөс 81,441.6 мянган төгрөгийн, БХНС арга хэмжээний зардлаас 100,181.3 мянган төгрөгийг зэрэг нийт **181,622.9** мянган төгрөгийг зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ноён голомт ХХК нь 2021 онд 150 тонн хуш модны самар түүж бэлтгэх гэрээ байгуулан төлбөрийг тус сумын төрийн сангийн дансанд урьдчилан шилжүүлсэн боловч ковид цар тахал гарч хорио цээр тогтоосны улмаас самар бэлтгэж чадаагүй байна. Иймд уг байгууллага нь дээрх төлбөрийг эргүүлэн авах нэхэмжлэх гаргасны дагуу **140,550.0** мянган төгрөгийг /Сэлэнгэ аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийдвэрээр/ буцаан олгохдоо ойн нөөцийн төлбөрийн орлогоос бууруулж, гүйлгээг хийсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4</b>	<b>1,526,578.96</b>	<b>7,239,021.84</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		927,893.61	4,566,697.27
33	АВЛАГА		365,915.47	374,288.74
35	БАРАА МАТЕРИАЛ	<b>6</b>	232,769.88	2,287,548.33
36	НӨӨЦИЙН БАРАА		-	10,487.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>13,998,831.91</b>	<b>14,006,755.30</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>13,998,831.91</b>	<b>14,006,755.30</b>
39200	Биет хөрөнгө		13,139,232.56	13,148,482.41
39300	Биет бус хөрөнгө		859,599.35	858,272.89
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>15,525,410.87</b>	<b>21,245,777.14</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9</b>	<b>420,289.52</b>	<b>1,824,733.03</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		420,289.52	1,824,733.03
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>15,105,121.36</b>	<b>19,421,044.11</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		15,105,121.36	19,421,044.11
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,461,774.50	1,461,774.50
51200	Хуримтлагдсан үр дүн		13,059,450.58	17,375,373.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		583,896.28	583,896.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>15,525,410.87</b>	<b>21,245,777.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тод-руулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>16,473,505.76</b>	<b>18,155,543.99</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>5,663,448.86</b>	<b>9,765,870.76</b>
110	Орлогын албан татвар		4,596,500.76	7,723,382.51
1100	Хувь хүний орлогын албан татвар		4,688,926.66	7,795,645.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-92,425.90	-72,262.89
113	Хөрөнгийн албан татвар		93,815.59	299,178.81
118	Бусад татвар, төлбөр, хураамж		973,132.51	1,743,309.44
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>7,251,998.17</b>	<b>8,389,673.22</b>
120	Нийтлэг татварын бус орлого		7,251,998.17	5,012,004.36
122	Тусламжийн орлого		-	278,336.56
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		-	3,099,332.30
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>3,558,058.73</b>	<b>-</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		458,664.53	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		3,099,394.20	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>7,310,775.52</b>	<b>9,258,969.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>6,936,261.83</b>	<b>8,429,806.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>5,746,726.41</b>	<b>7,672,562.64</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,348,750.14	1,547,311.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		174,724.32	185,897.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,566,659.32	1,657,296.21
2104	Хангамж, бараа материалын зардал		106,822.18	72,992.52
2105	Нормативт зардал		-	11,468.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		81,382.81	242,364.10
2107	Томилолт, зочны зардал		15,906.70	6,655.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		727,901.83	743,637.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,724,579.10	3,204,939.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>1,189,535.42</b>	<b>757,243.61</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>374,513.69</b>	<b>829,163.24</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>9,162,730.23</b>	<b>8,896,574.49</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>4,368,793.02</b>	<b>4,592,209.30</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-4,368,793.02</b>	<b>-4,592,209.30</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>4,793,937.21</b>	<b>4,304,365.19</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

  
 /мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,540,542.92</b>	<b>14,585,945.78</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>5,663,448.86</b>	<b>9,765,870.76</b>
110	Орлогын албан татвар	4,596,500.76	7,723,382.51
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,688,926.66	7,795,645.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-92,425.90	-72,262.89
113	Хөрөнгийн албан татвар	93,815.59	299,178.81
118	Бусад татвар, төлбөр, хураамж	973,132.51	1,743,309.44
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,371,439.43</b>	<b>4,820,075.02</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,371,439.43	1,467,687.08
122	Тусламжийн орлого	-	253,055.64
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	3,099,332.30
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,505,654.63</b>	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,630,184.17</b>	<b>7,194,871.70</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,630,184.17	7,194,871.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,440,648.75	6,440,495.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,540,049.18	1,796,422.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,673.09	187,412.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,579,483.79	1,700,179.12
2104	Хангамж, бараа материалын зардал	360,826.66	309,128.89
2105	Нормативт зардал	-	150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,683.85	226,231.90
2107	Томилолт, зочны зардал	15,906.70	5,965.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,332.40	289,033.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,415,693.08	1,925,971.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,189,535.42</b>	<b>754,376.60</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,910,358.75</b>	<b>7,391,074.08</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>5,479,761.88</b>	<b>3,662,770.42</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,479,761.88	3,662,770.42
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-5,479,761.88</b>	<b>-3,662,770.42</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	89,500.00
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	<b>-89,500.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-1,569,403.13</b>	<b>3,638,803.67</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,497,296.74	927,893.61
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	927,893.61	4,566,697.27

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,461,774.50</b>	<b>583,896.28</b>	<b>8,283,357.94</b>	<b>10,329,028.72</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-17,844.57	-17,844.57
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,461,774.50	583,896.28	8,265,513.37	10,311,184.15
4	Тайлант үеийн үр дүн	-	-	4,793,937.21	4,793,937.21
5	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,461,774.50</b>	<b>583,896.28</b>	<b>13,059,450.58</b>	<b>15,105,121.36</b>
6	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,461,774.50</b>	<b>583,896.28</b>	<b>13,059,450.58</b>	<b>15,105,121.36</b>
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	11,557.56	11,557.56
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,461,774.50	583,896.28	13,071,008.13	15,116,678.91
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,304,365.19	4,304,365.19
10	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,461,774.50</b>	<b>583,896.28</b>	<b>17,375,373.33</b>	<b>19,421,044.11</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/  
 1324100013 9033433

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>9,490,605.10</b>	<b>10,278,595.53</b>	<b>- 787,990.43</b>	<b>108.3</b>
<b>11</b>	<b>Татварын орлого</b>	<b>9,115,005.10</b>	<b>9,765,870.76</b>	<b>- 650,865.66</b>	<b>107.1</b>
110	Орлогын албан татвар	7,811,254.00	7,723,382.51	87,871.49	98.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,884,254.00	7,795,645.40	88,608.60	98.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 73,000.00	- 72,262.89	- 737.11	99.0
113	Хөрөнгийн албан татвар	285,534.20	299,178.81	- 13,644.61	104.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,018,216.90	1,743,309.44	- 725,092.54	171.2
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>375,600.00</b>	<b>512,724.77</b>	<b>- 137,124.77</b>	<b>136.5</b>
120	Нийтлэг татварын бус орлого	375,600.00	512,724.77	- 137,124.77	136.5
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,182,945.10</b>	<b>9,712,729.55</b>	<b>3,470,215.55</b>	<b>73.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,187,335.80</b>	<b>5,942,156.62</b>	<b>1,245,179.18</b>	<b>82.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,420,915.70</b>	<b>5,187,780.02</b>	<b>1,233,135.68</b>	<b>80.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,633,565.80	1,540,218.33	93,347.47	94.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,198.10	186,746.11	17,451.99	91.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,099,052.60	1,661,666.21	437,386.39	79.2
2104	Хангамж, бараа материалын зардал	96,768.10	56,947.90	39,820.20	58.8
2105	Нормативт зардал	1,150.00	150.00	1,000.00	13.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	272,203.20	244,163.90	28,039.30	89.7
2107	Томилолт, зочны зардал	12,700.00	5,965.00	6,735.00	47.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,766.10	33,303.44	30,462.66	52.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,037,511.80	1,458,619.13	578,892.67	71.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>766,420.10</b>	<b>754,376.60</b>	<b>12,043.50</b>	<b>98.4</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,610,609.30</b>	<b>3,681,072.93</b>	<b>1,929,536.37</b>	<b>65.6</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>385,000.00</b>	<b>89,500.00</b>	<b>295,500.00</b>	<b>23.2</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	813,524.62	- 813,524.62	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,392,320.20	- 4,392,320.20	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>94</b>	<b>94</b>	<b>0</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	4	4	0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>45</b>	<b>45</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	7	7	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21	23	2	109.5

620003	Үйлчлэх ажилтан	10	10	0	100.0
620004	Гэрээт ажилтан	7	5	-2	71.4
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>45</b>	<b>45</b>	<b>0</b>	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19	19	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	17	2	113.3
650010	Гэрээт ажилтан	7	5	-2	71.4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4	4	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>633,866.81</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>633,866.81</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>633,866.81</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>633,866.81</b>
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>633,866.81</b>
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,713.61
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	220,946.74
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	320,206.47
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>455,458.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>455,458.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>455,458.34</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,333.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	666.67
2104	Хангамж, бараа материалын зардал	2,025.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,899.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	440,533.26
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>178,408.47</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-178,408.47</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>-178,408.47</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **177,024.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **7,915.7** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **63,580.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **105,527.8** мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **71,496.4** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **25,630.9** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1.** Албан хаагчдад **7,915.7** мянган төгрөгийн цалин илүү тооцож, олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сумын ИТХ-ын дарга Т.Болдод 5,451.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон, нарийн бичгийн дарга Э.Болормаагийн 76.8 мянган төгрөгийн цалингийн өрийг суутгаагүй,
- Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги нь нягтлан бодогч П.Батмөнхөд 765.3 мянган төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалинг илүү, сахилгын шийтгэлтэй ахлах мэргэжилтэн Н.Буяндэлгэрт сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 1,622.0 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал тус тус олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон болон дутуу суутгасан цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1.** Бугант тосгоны Захирагчийн алба нь өөрийн орлогын төлөвлөгөөг **3,200.0** мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.** Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **16,953.4** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ТТЗ нь засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс Буурагчин хайрхны тахилгын зардалд 3,000.0 мянган төгрөг, самрын нөөц тогтоосны ажлын хүнсний зардалд 417.8 мянган төгрөг зэрэг нийт **3,417.8** мянган төгрөг,
- ЗДТГ нь сургалтын зардлаас багаж, техник хэрэгсэл худалдан авахад 1,076.0 мянган төгрөгийг, ажлын хэсгийн хоолны зардалд 719.1 мянган төгрөгийг, нэмэлт санхүүжилтийн данснаас үндсэн үйл ажиллагааны нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 7,000.0 мянган төгрөгийг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 1,150.0 мянган төгрөгийг зэрэг нийт **9,945.1** мянган төгрөг,
- Бугант захирагчийн алба нь нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас баяр наадмын зардалд 996.0 мянган төгрөгийг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 154.0 мянган төгрөгийг, цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 2,440.5 мянган төгрөгийг зэрэг нийт **3,590.5** мянган төгрөг зэрэг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйл: “Нөөц хөрөнгийн зориулалт”-ын 2.1.1-2.1.6 дугаар заалтууд болон 2.1.5: “..., энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”, 1.2 дахь “... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.”, 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3.** Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги нь ногоон сэргэлтийн бодлогын хүрээнд ойн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах төслөөр Ойн газраас нийт **31,071.6** мянган төгрөгийн ой хээрийн түймрийг унтраах багаж, хамгаалах хувцас

хэрэглэлийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй, жилийн эцэст уг хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.1 дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг тухай бүр бүртгэл тайланд тусгаж, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.4.** Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас үнэт цаасны төлбөрт **3,000.0** мянган төгрөгийг шилжүүлж, авлага үүсгэсэн боловч бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.5.** Анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар нийт **9,355.7** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Бугант тосгоны Захирагч Д.Эрдэнэбулганд холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр **583.2** мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон /2025 оны 1,2 дугаар сард тус тус 20 хувиар/,
- Ерөөгийн бүсийн сум дундын Ойн ангийн дарга Г.Энхбатад холбогдох албан тушаалтны шийдвэргүй, ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэлгүйгээр 1,906.7 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал, 1,062.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс, техникч Г.Төртогтоход “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар гүйцэтгэсэн ажлыг тодорхой тусгалгүйгээр 868.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс зэрэг нийт **3,837.5** мянган төгрөгийг тус тус олгосон,

- Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги нь бараа материалын **4,935.0** мянган төгрөгийн зарлагыг дарга, нягтлан бодогч, хүлээн авсан албан хаагчийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.4 дэх "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл бүрээр бичнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.6.** ЗДТГ-ын нягтлан бодогч Д.Золзаяа нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүйгээс батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан, нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй зэрэг зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу зөрчлийг давтан гаргасан ЗДТГ-ын нягтлан бодогч Д.Золзаяад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.3.1. Орлого, зарлагын төлөвлөлттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ нь санхүүгийн орлого, зарлагыг бодит байдалд үндэслэн, үнэн зөв төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулаагүй буюу үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож, тухайн жилийн нийт зардалд тусгаж төлөвлөөгүй, төсвийн жилийн дундуур халуун усны үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэсэн боловч төлөвлөгөөнд зохицуулалт хийгээгүйгээс орлого, зарлагын биелэлтийг хангаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ-ын 2025 оны төлөвлөгөө, төсөв"-ийг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бодит байдал, тооцоо судалгаанд үндэслэн орлого, зардлыг үнэн зөв төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах.

#### 5.3.2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 53 нэр төрлийн хөрөнгийг /ЗДТГ нь 22, Ерөөгийн бүсийн сум дундын ойн анги нь 31/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн ХЗУ<sup>1</sup>4-д "... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ..." гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

---

<sup>1</sup> ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

### **5.3.3. Цалин хөлстэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Бугант тосгоны захирагчийн алба нь жижүүр Ж.Төгсбаярын ээлжийн амралтын **1,165.6** мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын тайланд тайлагнаагүй нь НДШ, ХХОАТ-ын өр төлбөр үүсгэх эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 17.1.1: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Татвар ногдох орлогод дараах орлого хамаарна" 6.3.1 дэх "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж: Цаашид албан хаагчдын цалинг нийгмийн даатгал болон татварын тайланд бүрэн тайлагнаж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.

### **5.3.4. Анхан шатны баримттай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ нь анхан шатны бүрдэл дутуу баримтаар буюу өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **6,700.5** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

### **5.3.5. Мөнгөн кассын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ нь халуун усны үйлчилгээнд бэлэн мөнгө хураах орлогын талоныг ашиглаагүй, иргэдэд цахим төлбөрийн e-баримтыг

бүрэн гаргаж өгөөгүй зэрэг халуун усны орлогод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж: Халуун усны орлого, төлбөрийн е-баримт зэргийг тухай бүр тулган баталгаажуулж, хяналт тавьж ажиллах.

### **5.3.6. Авлагын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус сумын авлага дансны үлдэгдэлд **97,304.7** мянган төгрөгийн дараах авлагууд тайлагнагдсан боловч өнөөг хүртэл барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Үүнд:

- ОНХО-ын дансанд 2006 онд олгосон итгэлийн зээлийн 8,180.0 мянган төгрөгийн,
- ОНХС-ын авлагын дансны үлдэгдэлд ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжсэн бохирын машин нийлүүлэх тендерт шалгарсан компанид шилжүүлсэн урьдчилгаа 14,000.0 мянган төгрөгийн /шүүхийн шийдвэр гарч төлүүлэх шийдвэр гарсан боловч төлбөрийн чадамжгүйгээс одоог хүртэл барагдаагүй байна./, 2022 онд хүүхдийн тоглоомын талбай хийлгэх ажлын урьдчилгаа 12,000.0 мянган төгрөгийн /Цагдаагийн байгууллагад материалыг бүрдүүлэн өгсөн боловч шийдвэр нь гараагүй байна./,
- ХХС-ийн авлагын дансанд 2010-2011 онд олгосон итгэлийн зээлийн 20,820.5 мянган төгрөгийн, 2011-2015 онуудад олгосон 10 иргэний хугацаа хэтэрсэн зээлийн 42,304.2 мянган төгрөгийн зэрэг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

### **5.3.7. Ээлжийн амралттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нягтлан бодогч Б.Жавхланзаяагийн ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлэлгүйгээр нийт **357.0** мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр

ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ ...” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ээлжийн амралтыг биеэр эдлүүлэн, батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

**6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийт дүн												

/мянган төгрөгөөр/

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	100,722.5			1	3,417.8	1	97,304.7				
ИТХ	1	5,528.4	1	5,528.4								
ЗДТГ	3	9,945.1			1	9,945.1	1		1	1		
Бугант тосгоны Захирагчийн алба	5	8,896.3			3	7,373.7	2	1,522.6				
Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги	5	45,231.4	1	2,387.3	3	42,844.1	1					
Төгөлдөр ерөө ОНӨААТҮГ	3	6,700.5					3	6,700.5				
<b>Дүн</b>	<b>19</b>	<b>177,024.2</b>	<b>2</b>	<b>7,915.7</b>	<b>8</b>	<b>63,580.7</b>	<b>8</b>	<b>105,527.8</b>	<b>1</b>	<b>1</b>		

/мянган төгрөгөөр/

Үүнээс

